



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/02/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Батчимэг

Утас: 88094175 Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2024.02.06 № 01/15  
танай 2024.01.16-ны № 20 -Т

ХОВД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГА Ц.МЯГМАРСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн газар нь батлагдсан орон тооноос 15 орон тооны ажлын байрыг бусад ажилтнаар ажлуудыг хавсран гүйцэтгүүлж байна. Энэ нь байгууллагын ажилтнуудын ажлын бүтээмж, чанарт нөлөөлж болзошгүй байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан ДЭМБ-с 28.3 сая, аймгийн ОНХС-аас 19.0 сая, МоЭнКо ХХК-аас 14.1 сая төгрөг, МСЭМХолбооноос 19.3 сая, ЭМЯ-наас 74.8 сая төгрөг нийт 190.7 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар Нахиа-Импекс ХХК-д өмнөх оны 10.5 сая төгрөгийн эмийн зардлын өрийг төлсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн газар нь аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан 5 зорилтын хүрээнд 17 арга

хэмжээ, Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 7 зорилтын хүрээнд 24 арга хэмжээ, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд 3 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд 5 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ нийт 13 зорилтын хүрээнд 66 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 96.7 хувьтай гүйцэтгэн ажиллажээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,148,798,021.83</u></b>	<b><u>885,487,167.66</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	7,586,602.00	12,369,190.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,622,602.00	1,476,898.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,964,000.00	10,892,292.00
3351	Байгууллагаас авах авлага	153,000.00	9,081,292.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,811,000.00	1,811,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,141,211,419.83	873,117,977.66
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,070,762,801.27	833,930,297.63
35130	Эм боох материал	1,070,762,801.27	833,930,297.63
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	70,448,618.56	39,187,680.03
35410	Бичиг хэргийн материал	6,937,575.00	6,918,575.00
35440	Түлш, шатах тослох материал	545,000.00	105,000.00
35470	Бусад хангамжийн материал	62,751,043.56	32,164,105.03
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>654,257,708.23</u></b>	<b><u>719,671,450.50</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	654,257,708.23	719,671,450.50
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	607,977,908.23	673,391,650.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	500,013,000.00	500,013,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35,790,294.64	-44,271,305.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	197,956,615.00	197,956,615.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-144,625,731.36	-168,206,615.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	346,106,484.90	409,243,055.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-270,944,693.43	-244,923,646.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,336,206.00	55,034,954.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,073,678.24	-31,454,407.50
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	46,279,800.00	46,279,800.00
39303	Бусад биет бус хөрөнгө	46,554,800.00	46,554,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,803,055,730.06</u></b>	<b><u>1,605,158,618.16</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,802,915,141.06</u></b>	<b><u>1,605,158,618.16</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,802,915,141.06	1,605,158,618.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,173,950,895.00	1,173,950,895.00
51101	Өмч: - төрийн	1,173,950,895.00	1,173,950,895.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	238,046,279.58	40,746,643.68
51210	Өмнөх үеийн үр дүн	238,046,279.58	238,503,166.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-197,756,522.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	390,917,966.48	390,461,079.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,803,055,730.06</u></b>	<b><u>1,605,158,618.16</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>5,264,197,900.23</u></b>	<b><u>4,345,202,661.62</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>2,235,761,674.23</u></b>	<b><u>1,686,876,070.62</u></b>

<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,235,761,674.23	1,686,876,070.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,235,761,674.23	1,686,876,070.62
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,235,761,674.23	1,686,876,070.62
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,028,436,226.00</b>	<b>2,658,326,591.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,916,686,500.00	2,467,703,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,916,686,500.00	2,467,703,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	111,645,560.00	190,623,291.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	126,995,731.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,156,000.00	19,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,704,560.00	44,627,560.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,710,775,155.04</b>	<b>4,542,959,184.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,710,775,155.04</b>	<b>4,542,959,184.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,409,604,511.73	2,904,086,611.58
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	428,074,864.00	641,099,134.70
210101	Үндсэн цалин	268,889,274.00	373,215,959.20
210102	Нэмэгдэл	85,936,503.00	188,827,450.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,620,286.00	28,245,000.00
210104	Урамшуулал	47,628,801.00	50,810,725.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,797,373.69	79,048,715.96
210201	Тэтгэврийн даатгал	36,866,312.87	54,679,685.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,355,925.03	6,432,551.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,461,220.49	4,839,680.99
210204	Ажилгүйдлийн даатгал	828,537.71	1,424,726.40
210205	Эрүүл мэндийн даатгал	8,285,377.59	11,672,071.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	50,140,312.00	57,534,809.92
210301	Гэрэл, цахилгаан	4,858,627.00	5,002,849.92
210302	Түлш, халаалт	41,227,725.00	48,478,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,053,960.00	4,053,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	41,624,329.00	40,541,876.48
210401	Бичиг хэрэг	7,753,600.00	8,968,600.00
210402	Тээвэр, шатахуун	28,175,230.00	26,781,016.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,490,376.00	1,718,510.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,378,040.00	424,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,827,083.00	2,649,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,290,749,900.96	1,743,726,361.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,290,749,900.96	1,743,366,361.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	360,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	364,629,416.50	10,674,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	336,612,446.50	983,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	829,600.00
210604	Урсгал засвар	27,816,970.00	8,861,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,755,000.00	32,715,000.00
210702	Дотоод албан томилолт	10,755,000.00	32,715,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,110,300.00	7,552,803.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,390,000.00	1,116,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	101,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,960.00	116,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	24,700.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,878,700.00	5,268,343.52
210807	Газрын төлбөр	503,190.00	925,560.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>155,723,015.58</b>	<b>291,193,209.25</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,275,923.00	254,165,306.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,083,700.00	529,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,363,392.58	36,498,902.33
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,301,170,643.31</b>	<b>1,638,872,572.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,253,010,640.00</b>	<b>1,535,228,125.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,091,972,426.00	929,837,578.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,153,884,048.00	589,205,547.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,050,000.00	16,185,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>48,160,003.31</b>	<b>103,644,447.94</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,007,003.31	103,644,447.94
213304	Хөрөнгийн		
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>553,422,745.19</u></b>	<b><u>-197,756,522.90</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>553,422,745.19</u></b>	<b><u>-197,756,522.90</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,127,671,095.00	558,734,375.17	-907,620,917.29	778,784,552.88
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,054,949.00	1,054,949.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,127,671,095.00</b>	<b>558,734,375.17</b>	<b>-906,565,968.29</b>	779,839,501.88
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-1,054,949.00	00.00	-1,054,949.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	114,133,038.22	114,133,038.22
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,173,950,895.00</b>	<b>390,917,966.48</b>	<b>238,046,279.58</b>	1,802,915,141.06
D01	<b>2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>1,173,950,895.00</b>	<b>390,917,966.48</b>	<b>238,046,279.58</b>	1,802,915,141.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	456,887.00	456,887.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,173,950,895.00</b>	<b>390,917,966.48</b>	<b>238,503,166.58</b>	1,803,372,028.06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-456,887.00	00.00	-456,887.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-197,756,522.90	-197,756,522.90
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,173,950,895.00</b>	<b>390,461,079.48</b>	<b>40,746,643.68</b>	1,605,158,618.16

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>3,028,436,226.00</u></b>	<b><u>2,658,326,591.00</u></b>

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,028,436,226.00</b>	<b>2,658,326,591.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,916,686,500.00	2,467,703,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,916,686,500.00	2,467,703,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	111,645,560.00	190,623,291.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	126,995,731.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,156,000.00	19,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,704,560.00	44,627,560.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,028,436,226.00</b>	<b>2,654,641,591.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,028,436,226.00</b>	<b>2,654,641,591.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>727,280,582.69</b>	<b>1,001,923,890.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	428,032,275.00	636,996,019.70
210101	Үндсэн цалин	268,846,685.00	369,054,940.20
210102	Нэмэгдэл	85,936,503.00	188,885,354.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,620,286.00	28,245,000.00
210104	Урамшуулал	47,628,801.00	50,810,725.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,797,373.69	79,048,715.96
210201	Тэтгэврийн даатгал	36,866,312.87	54,679,685.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,355,925.03	6,432,551.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,461,220.49	5,097,640.99
210204	Ажилгүйдлийн даатгал	828,537.71	1,166,766.40
210205	Эрүүл мэндийн даатгал	8,285,377.59	11,672,071.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	50,140,312.00	57,534,809.92
210301	Гэрэл, цахилгаан	4,858,627.00	5,002,849.92
210302	Түлш, халаалт	41,227,725.00	48,478,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,053,960.00	4,053,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,358,864.00	36,102,646.00
210401	Бичиг хэрэг	4,404,800.00	7,639,750.00
210402	Тээвэр, шатахуун	17,568,565.00	24,359,196.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,490,376.00	1,849,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,691,940.00	967,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,203,183.00	1,286,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	112,400.00	58,685,267.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	112,400.00	54,814,167.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,871,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,381,070.00	12,382,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,732,000.00	1,423,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	596,000.00	1,265,400.00
210604	Урсгал засвар	27,053,070.00	9,693,300.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	10,755,000.00	32,715,000.00
210702	Дотоод албан томилолт	10,755,000.00	32,715,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,954,000.00	6,937,770.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,390,000.00	1,122,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	101,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,960.00	116,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	24,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,722,400.00	4,647,310.00
210807	Газрын төлбөр	503,190.00	925,560.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	108,749,288.00	81,611,461.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,763,588.00	80,867,861.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,985,700.00	743,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,301,155,643.31</b>	<b>1,652,717,700.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,252,995,640.00	1,539,991,961.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,091,972,426.00	967,302,181.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,153,884,048.00	556,539,780.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,035,000.00	16,150,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>48,160,003.31</b>	<b>112,725,739.94</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,007,003.31	103,644,447.94
213304	Хөрөнгийн		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,685,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-3,685,000.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,468,554,900.00	2,364,058,852.06
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,468,554,900.00	2,364,058,852.06
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	938,718,900.00	839,266,891.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>702,999,100.00</b>	<b>632,850,315.70</b>
210101	Үндсэн цалин	405,691,800.00	364,909,236.20
210102	Нэмэгдэл	214,753,100.00	188,885,354.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,280,000.00	28,245,000.00
210104	Урамшуулал	44,274,200.00	50,810,725.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>90,794,900.00</b>	<b>79,048,715.96</b>
210201	Тэтгэврийн даатгал	61,740,500.00	54,679,685.40
210202	Тэтгэмжийн даатгал	7,263,600.00	6,432,551.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,810,900.00	5,097,640.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,452,700.00	1,166,766.40
210205	Эрүүл мэндийн даатгал	14,527,200.00	11,672,071.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>58,062,500.00</b>	<b>57,534,809.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,526,900.00	5,002,849.92
210302	Түлш, халаалт	48,478,000.00	48,478,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,057,600.00	4,053,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,382,200.00</b>	<b>19,420,466.00</b>
210401	Бичиг хэрэг	7,852,900.00	6,769,750.00
210402	Тээвэр, шатахуун	13,730,000.00	9,737,016.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	749,800.00	749,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	967,800.00	967,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,081,700.00	1,196,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,512,400.00</b>	<b>4,099,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	228,600.00	228,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,283,800.00	3,871,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,535,200.00</b>	<b>16,067,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,576,500.00	5,108,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,265,400.00	1,265,400.00
210604	Урсгал засвар	9,693,300.00	9,693,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,670,400.00</b>	<b>7,047,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	10,670,400.00	7,047,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,239,200.00</b>	<b>6,937,770.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,122,000.00	1,122,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	213,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	101,800.00	101,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,400.00	116,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	24,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,735,200.00	4,647,310.00
210807	Газрын төлбөр	925,900.00	925,560.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19523000.00</b>	<b>16,260,913.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,549,900.00	15,287,813.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	973,100.00	973,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1529836000.00</b>	<b>1,524,791,961.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,529,836,000.00</b>	<b>1,524,791,961.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	971,285,900.00	967,302,181.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	557,203,100.00	556,539,780.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,347,000.00	950,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,468,554,900.00	2,364,058,852.06
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>30.00</b>	<b>30.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	26.00	26.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>190,623,291.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>190,623,291.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	166,341,999.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,145,704.00
210101	Үндсэн цалин	4,145,704.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,592,180.00
210401	Бичиг хэрэг	870,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,622,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	54,585,567.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,585,567.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	25,668,000.00
210702	Дотоод албан томилолт	33,768,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	57250548.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,250,548.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15200000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	15,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,200,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	190623291.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	190,623,291.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	126,995,731.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,627,560.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 50,793.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 21,615.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 29,178.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 50,793.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 3,042.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 26,135.1 сая төгрөгийн зөрчил арилгуулах 2 албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

- 1. Албан томилолтын тооцоо илүү бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дугаар 120 дугаар тушаалын 1 дэх хэсэгтэй нийцээгүй байна.
- 2023 оны 2 дугаар улирлын урамшууллыг олгоходоо 7 дугаар сард нэмэгдсэн цалингаас тооцон олгосон Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т “Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцээгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 5.2 Албан шаардлага

- Нийт албан хаагчдад үр дүнгийн урамшуулал илүү, цалингийн хэмнэгдсэн зардлаас албан хаагчдад түлээ нүүсний хөнгөлөлт олгосон нь Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалтын “40” гэснийг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; “16.5.4-д төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам”-н 8.3 ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно гэсэн заалтуудтай нийцээгүй.
- Цалингийн зардлаас шагнал урамшуулалд зарцуулсан, албан хаагчдын хувийн хэрэгцээнд бараа материал олгосон, даргын нэрэмжит шагнал урамшуулал, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс гар утасны төлбөр төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Төсвийн тухай хуулийн 16 дугаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусгаан илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам"-н 8.3. Ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй.

Албан шаардлага хүргүүлсэн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хүний нөөцтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Байгууллагын албан хаагчдын 42 хувь нь төрийн жинхэнэ албан хаагчийн ажлыг орлон гүйцэтгэн цалин олгож байгаа нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-д Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн албаны тухайн хуулийн 27 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Тайлант оны элэгдэлийн зардал дутуу тооцоолон бодсон	1	21,618.80			1.00	21,618.80	1.00	21,618.80				
Дүн		21,618.8	-	-	1	21,618.8	1	21,618.8	-	-	-	

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Албан томилолтын тооцоо илүү олгосон	1	142.0	1	142.00						-	-	-	-
Албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшуулал 7 дугаар сард нэмэгдсэн цалингаас тооцон олгосон	1	2,900.9	1	2,900.90									

Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал тогтоолоос илүү тооцон олгосон, цалингийн хэмнэгдсэн зардлаас албан хаагчдад түлээ нүүсний хөнгөлөлт олгосон	1	19,204.4	0	0.00	1	19204.4						
Цалингийн сангаас урамшуулалт цалин, даргын нэрэмжит шагнал,төсөл хөтөлбөрөөс гар утасны төлбөр төлсөн	1	6,930.7	0	0.00	1	6930.7						
Төрийн албанны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-д Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх	1	-					1	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>29,178.0</b>	<b>2.0</b>	<b>3,042.9</b>	<b>2.0</b>	<b>26,135.1</b>	<b>1.0</b>	<b>-</b>				



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 06 сарын 06

Дугаар 9.1 А2171039

Ховд

ХОА-2024/02/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Албан томилолтын мөнгийг илүү бодож олгосон нь зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнөө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно," Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

3. Дээр дурдсан 142.0 /нэг зуун дөчин хоёр мянган / төгрөгийг хавсралтад дурдсан ажилчдаас суутган тооцож Төрийн сан банкин дахь бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2024 оны 5 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
4. Актын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 30-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>2</sup> ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэн, нягтлан бодогч С.Мөнх-Уянга нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АУДИТОР

У.БАТЧИМЭГ

<sup>2</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагарае баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 07/АД/41039

Ховд

ХОА-2024/02/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд: Нийт албан хаагчдад цалингийн хэмнэгдсэн зардлаас үр дүнгийн урамшуулал 7.5 сая төгрөг, 2023 оны 12 дугаар сард нийт албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт 11.7 сая төгрөг нийт 19.2 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалтын "40" гэснийг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам"-н 8.3-д "ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Төрийн захиргааны албан хаагч нарт үр дүнгийн мөнгөн урамшуулал, ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын олгохдоо Монгол улсын засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах.
- Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 30-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>3</sup> ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэн, нягтлан бодогч С.Мөнх-Уянга нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

У.БАТЧИМЭГ

<sup>3</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагараев баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 08/АДН/1039

Ховд

ХОА-2024/02/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд: Цалингийн зардлаас шагнал урамшуулалд, албан хаагчдын хувийн хэрэгцээнд бараа материал олгосон, даргын нэрэмжит шагнал урамшуулал, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс гар утасны төлбөр нийт 6.9 сая төгрөгийг олгосон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох," Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн "16.5.4-д төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллын дагуу зарцуулан ажиллах.
- Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 30-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>4</sup> ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэн, нягтлан бодогч С.Мөнх-Уянга нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

АУДИТОР  У.БАТЧИМЭГ

АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХУУДАС

<sup>4</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагарае баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545

